



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/299

Зуунмод

Газар эзэмших
эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Тулгаа овогтой Оюунчимэг /ХЛ63031820/-ийн 000506939 дугаар бүхий гэрчилгээтэй нэгж талбарын 18646287757546 дугаартай Баруун Зуунмод 6-р баг, Ирээдүй хотхон 226А тоотод орон сууцны зориулалттай 522 м² газрын эзэмших эрхийг Цэвээндорж овогтой Энхбаяр /НЮ82122777/-т орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаагаар эрх шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Ц.Энхбаярт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/415 дугаар захирамж болон газар эзэмших эрхийн 000506939 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

010 000777